



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

136 /136/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.09.16

ҮЙЛ ЯВДАЛ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 015 ДУГААР АНГИЙГ О.СЭРДАРЫН НЭРЭМЖИТ БОЛГОЛОО

Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит хуралдаанаар Зэвсэгт хүчний 015 дугаар ангийг Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хурандаа Осорын Сэрдарын нэрэмжит болголоо. Хурандаа Сэрдар нь Зэвсэгт хүчний хөгжил дэвшил, зэвсэглэлийн төв баазыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, зэвсгийн мэргэжлийн шинэ боловсон хүчнийг бэлтгэх үйлсэд хүчин зүтгэж, пуужинт-артиллерийн зэвсэглэлийн удирдлагын баримт бичгийг анхлан боловсруулсан төдийгүй Зэвсэгт хүчний 015 дугаар ангийг олон жил удирдан ажиллаж байсан цэргийн зэвсгийн шилдэг мэргэжилтэн, багш, манлайлагч байсан юм.



Түүхэнд энэ өдөр

1939 он:

Москвад болсон хэлэлцээрийн дагуу Халхын голын районд хоёр тал байлдааны ажиллагааг зогсоохоор болжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	☁️ 4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	☁️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,844.00	2,855.00
EUR 🇪🇺	3,341.0	3,395.0
CNY 🇨🇳	440.50	444.90
RUB 🇷🇺	38.60	40.30
JPY 🇯🇵	25.77	26.26
KRW 🇰🇷	2.35	2.48

ЗУРХАЙ

2021.09.16 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 10/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН НЭГ ЦАГААН УЛААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихэснэ.

Наран ургах, шингих:

06.31-19.03

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал:

Огторгуй

Аргын тооллын 9 дүгээр сарын 16, Бархасвад гараг. Билгийн тооллын 10, Элдэв тэнгэртэн одтой, улаагчин туулай өдөр. Өдрийн наран 6 цаг 31 минутад мандан, 19 цаг 03 минутад жаргана. Тухайн өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адуус номхруулах, угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, багаадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч нэмнэ.



ЦЭРГИЙН АЛБЫГ ЦЭРГИЙН МУЗЕЙД "ХААГААРЙ"




Энэхүү буланд хугацаат цэргийн алба хаагчдын өдөр тутамдаа хийдэг зүйлсийг үзэгч та өөрөө хийж үзэх нээлттэй боломжийг олгож байна. Дөрвөлжин шоо мэт ирмэг гарган цэргийн хуарангийн ороо хураах, захны даавуу, мөрдэс хадах, хөлөө жийрэглэн ороох гэх мэт зүйлсийг өөрийн биеэр хийж үзэхээс гадна үе үеийн цэргийн дүрэмт хувцаснаас сонгон өмсөж дурсгалын зураг татуулан өөртөө үлдээгээрэй.

Эр хүний мэдэх, сурах ёстой энгийн боловч эв дүй шаардсан хувь хүний соёл, биеэ авч явах эрдмийн нэгээхэн хэсгийг сурч биеэр хийж үзнэ үү хэмээн үзэгч та бүхнийг урьж байна.

Мөн хүүхэд, залуусын сонирхлыг татахуйц буудлагын тийрийг боловсролын танхимдаа ажиллуулж байна. Уг буудлагын тийрэнд 2 төрлийн бугаар буудах ба зориулалтын зөөлөн сумаар буудна. Таны аюулгүй байдлыг бүрэн хангасан болно.



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЭВ



ҮБХИС-ийн БХЭШХ-гээс санаачлан Афганистан Улсад үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багуудын төлөөлөлтэй "Афганистаны ажиллагааны туршлага, сургамж" сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлээ. Хэлэлцүүлэгт тус хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид болон Афганистан Улсад үүрэг гүйцэтгэсэн цэргийн багийн захирагч нар хамрагдан тодорхой сэдвүүдээр илтгэл тавьж харилцан ярилцав.

ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчний Артиллерийн цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн угтвар аянд түүхнээ 50-тын салаа дуугаараа мөнхөрсөн 1980 оны элсэлтийн Артиллерийн "Б" курсийн хамт олон нэгдэж бусад артиллерчдаа манлайлан Артиллерийн цэргийн холбооны дэд тэргүүн домогт хурандаа Доржханд, Артиллерийн цэргийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, хурандаа Гантулга нар улаан залаат их буудчдынхаа алдрыг мөнхлөх үйлсэд өөрсдийн эхний шатны хандиваа гардууллаа.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 257,544 +2737	ЭДГЭРСЭН 248,723 +5680	НАС БАРСАН 1032 +10
-----------------------------------	---------------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4911 +83	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 195	ЭДГЭРСЭН 4623
-----------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 227,252,757
Эдгэрсэн Нийт: 203,937,481
Нас барсан Нийт: 4,673,481

Үйл явдал

ЦЭРГИЙН ЧУУЛГЫНХАН “ЦУСАА БЭЛЭГЛЭЭ АЯН”-Д НЭГДЛЭЭ

ЦДБЭЧ-ын хамт олон Цус сэлбэлт, судлалын үндэсний төвтэй хамтран “Цусаа бэлэглэе” хүмүүнлэгийн аянд нэгдлээ.

“Цар тахлын нөхцөл байдалтай холбоотой цусны хомсдол үүсэх эрсдэл өндөр байгаа энэ цагт уг аян нь үнэхээр нүдээ олсон үйл явдал юм” гэж ЦДБЭЧ-ын дарга, Соёлын төв өргөөний Ерөнхий менежер, хурандаа Г.Золзаяа хэлэв.

Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн олон нийт, маркетингийн менежер Р.Энхтуяа “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн жилд 2-3 удаа тус өдөрлөгт нэгддэг. Цар тахал болон бусад өвчин эмгэгийн халдвар их байгаа энэ үед цусны хэрэглээ улам л нэмэгдэж байна. Ийм цаг үед ЦДБЭЧ-ын хамт олон маш идэвхтэй оролцонд талархъя. Манай Цус сэлбэлт, судлалын үндэсний төв маань одоогоор



80 гаруй улс болон хувийн эмнэлгүүдэд цус, цусан бүтээгдэхүүнийг нийлүүлж байна. Таны бэлэглэсэн цус

хамгийн багадаа гурван хүний насыг авардаг юм шүү” гэж цэргийн алба хаагчдад амжилт хүссэн юм.

ТАМИРЧИД БАХДАМ АМЖИЛТ ҮЗҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Зэвсэгт хүчний аварга шалгаруулах 2021 оны уралдаан тэмцээнд тус анги амжилттай оролцож байна. ЦСЦ-ын 5

төрөлтийн тэмцээнд дэслэгч Б.Баасанцэрэн, дэд ахлагч С.Нандин-Эрдэнэ нар алт, эмэгтэй баг алтан медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр тэргүүн байрт шалгаран цомын эзэд боллоо.

Саадын зурвас буухиа төрөлд эрэгтэй баг мөнгө, эмэгтэй баг хүрэл медаль хүртэж багийн нэгдсэн дүнгээр IV байрт шалгарав.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ

"ОРОЛЦОО" ТӨСӨЛ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖИВ

БХЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам хамтран залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг хэрэгжүүлж буй. Тэгвэл залуучуудад эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгож, ажилтай, орлоготой болгох зорилготой уг төслийн хүрээнд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Сургалтын төвд 18-34 насны, сүүлийн 3 сар ажил, хөдөлмөр эрхлээгүй, их, дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцаагүй, ажилтай, орлоготой болж ирээдүйгээ өөрчлөх хүсэлтэй залуусыг хамруулсан 14 хоногийн вакумжуулсан тэтгэлэгт багц сургалтад хамрууллаа.

Сургалтын хаалтын ажиллагаанд ЗХЖШ-ын АУГ-ын дарга, бригадын генерал Д.Дашзэвэг, Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Л.Дашдэмбэрэл, ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, төслийн зохицуулагч Х.Тамираа, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагч хурандаа Ц.Буянжаргал нар оролцож төслийн сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд баяр хүргэж, гэрчилгээ гардуулан цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилтыг хүслээ.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор, Мэргэжлийн боловсрол сургалт, Түүнчлэн Зэвсэгт



мэдээлэл арга зүйн төвөөс томилогдсон багш нар болон бүлгийн удирдагч нарын зохион байгуулсан сургалтын үр дүнд оролцогчид өөрийгөө таньж мэдэх, сэтгэл хөдлөлөө удирдах, алсын хараа хэтийн зорилгоо тодорхойлж, ажлын байрны ёс суртахууныг ойлгож, ажил мэргэжлийн чиг баримжаагаа олох, зөв амьдралын дадал хэвшилд суралцсан гэдгээ онцолсон юм. Цаашид ч тодорхой хугацаанд дадлагад хамрагдаж ажлын байр, орлоготой болох бүрэн боломжтой аж.

Мөн Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиас томилогдсон бүрэлдэхүүн бэлтгэл ажлын хүрээнд оролцогчдын амьдрах, сурч боловсроход таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, удирдлага зохион байгуулалт, ар талын хангалтыг тасалдалгүй зохион байгуулж, эмнэлгийн бүлгийн бүрэлдэхүүн эрүүл мэндийн байдалд нь хяналт тавин шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллажээ. Түүнчлэн Зэвсэгт

хүчний анги, байгууллагаас томилогдсон офицер ахлагч нар салаа биеийн тамирын бэлтгэл, жагсаалын бэлтгэл, сэтгэл зүйн хангалт, эмнэлгийн анхны тусламж зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсны зэрэгцээ “Таван цагираг” цогцолбор тэмцээн, “Эх орны эзэд” марш тактикийн тэмцээнийг явуулж оролцогчид цэрэгжлийн спорт болон цэргийн алба хаагчдын өдөр тутамд гүйцэтгэдэг үүргүүдийн талаар ойлголт өгчээ.

Хаалтын ажиллагааны төгсгөлд ЗХЖШ-ын АУГ-ын дарга бригадын генерал Д.Дашзэвэг, Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Л.Дашдэмбэрэл, ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, төслийн зохицуулагч Х.Тамираа нар тус сургалтын агуулга, хэлбэр, ач холбогдлын талаар харилцан санал солилцлоо.

ТАЛИБАНЫ ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ

Талибан гэж хэн бэ?

Талибан нь пушту үндэстний хэлээр сурагч гэсэн утгатай үг бөгөөд Афганистаны пуштууудын дунд 1994 онд бий болсон Исламын шашны хэт дэвсгэрийн хөдөлгөөнийг нэр гэж ойлгож болно. Тэд 1996 оны 9 дүгээр сараас 2001 оны 12 дугаар сар хүртэл Афганистаны Исламын Эмират нэртэй Улсыг байгуулж, нийслэлээрээ Кандагар хотыг нэрлэж байв. Тус улсыг Пакистан, Саудын Араб, Арабын нэгдсэн Эмират улсууд албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдаг.

Талибан бүлэглэл нь эхэндээ Зөвлөлтийн цэргүүдтэй хийсэн дайнд оролцсон ахмад дайчид, Пакистаны тусгай албаны дэмжлэгтэйгээр сурагч бэлтгэгдсэн пуштун дүрвэгсдээс бүрдэж байжээ. Талибаны үзэл суртал нь Исламын шашныг ариун байлгахад чиглэгддэг бөгөөд уг үзэл санаагаа орон нутгийн пуштун зан заншилтай хослуулан авч явдаг ажээ. Тэд 1996 онд Исламын шашны ёс уламжлал, сахилга батыг сэргээх, Афганистанд энх тайвныг тогтоох зорилготойгоор дайн эхлүүлж, улсынхаа Засгийн эрхийг авч чадсан юм.

Тэдний хяналтад байдаг нутаг дэвсгэртээ шашны хатуу хяналт, хориг тавьдаг. Тухайлбал, телевиз, хөгжим, хөгжмийн зэмсэг, дүрслэх урлаг, согтууруулах ундаа, компьютер, интернэт, шатар, цагаан гутал (цагаан бол талибанчуудын далбааны өнгө юм), бэлгийн харилцаа, тийм утга бүхий үг хэллэгээр ярих гэх мэт зүйлс багтдаг байна. Эрэгтэйчүүд тодорхой заасан урттай сахал тавих шаардлагатай. Эмэгтэйчүүдийг ажил хийх, эрэгтэй эмч нараар эмчлүүлэх, олон нийтийн газар нээлттэй нүүр царайгаа ил гаргах, нөхөр эсвэл эрэгтэй хамаатангүйдээ гадуур явахыг хориглодог. Мөн эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших боломж нэлээд хязгаарлагдмал (2001 онд охид сургуулийн ирцийн дөнгөж 1 хувийг эзэлж байв) байсан.

2001 оны 9 дүгээр сарын 11-ний халдлагын дараа Америк болон НАТО-гийн орны цэргүүд Талибан хөдөлгөөний эрх мэдэлд байсан Засгийн газрыг унагасан. Гэсэн ч Талибаны дэмжигчид ууланд гарч партизаны урт удаан дайныг эхлүүлсэн юм. 2003 он гэхэд тус хөдөлгөөн Афганистан, Пакистанд дахин сэргэж, үе үе террорист үйл ажиллагаа явуулах болсон. Хамид Карзайн Засгийн газрын дэмжлэгтэйгээр НАТО-гийн орнууд цэргийн ажиллагаа явуулж байсан ч талибанчууд хэд хэдэн бүс нутагт нөлөөгөө сэргээж чадсан байдаг.

Талибан бүлэглэлийг хэн удирддаг вэ?

1996 онд Засгийн эрхийг авахын төлөөх тулалдаанд Талибан бүлэглэлийг ЗХУ-ын эсрэг олон жилийн дайн үзэж, ёстой л хал үзэж, хашир суусан ахмад дайчин Мулла Мохаммед Омар удирдан явуулсан байдаг. Тэр бээр үзэл суртлын маш хатуу дэгийг тогтоогоод зогсохгүй өрнийн ба орчин үеийн бүх зүйлийг үл таална. Талибанчууд Кабулыг 1996 онд эзлэн авч, 1997 онд Герат, Мазари-Шарифт хяналтаа тогтоосон. 2000 он гэхэд Афганистаны нутаг дэвсгэрийн 90 орчим хувийг гартаа оруулжээ.

Түүнийг Талибан бүлэглэлийн үндэслэгч гэж албан ёсоор үздэг. Гэвч 2013 онд Америкуудын явуулсан агаарын дайралтын дүнд түүнийг устгасан боловч талибанчуудын зүгээс түүнийг үхсэн гэдгийг 2016 он хүртэл хүлээн зөвшөөрөөгүй юм. Мулла Мохаммедыг үхсэний зарласны дараа Мавлави Хайбулла өөрийгөө дараагийн удирдагчаар зарласан. Албан бус эх сурвалжийн мэдээллээр Пакистан дахь нууц “Кузтта Шура” хэмээх баазд тэр бээр байрлаж, Талибан бүлэглэлийн бодлого, төлөвлөгөөг боловсруулдаг ажээ. Түүний улс төрийн орлогч сайд Муллах Абдул Гани АНУ-тай хэлэлцээр хийж, 20 жил үргэлжилсэн цуст дайныг төгсгөл болгосон юм.

Тэд хэрхэн мөнгө хийдэг вэ?

Талибанчуудын хамгийн гол орлого олдог суваг нь хар тамхины тариалалт, наймаа юм. Тэдний хяналтад байдаг тариаланчдаас гэд татвар авна. Мөн хилийн чанадад орших тэдний нөлөөнд байдаг газрын тосны худалдаа эрхлэгчид байдаг. Мөн хууль бус үнэт металл олзворлогч бичил уурхайнууд тэдний хяналтад байдаг. Мөн тэднийг гаднаас нь дэмждэг хувь



хүн, байгууллагууд нэлээд бий. Ялангуяа Пакистан, Персийн булангийн орнуудын зарим нөлөө бүхий хүмүүс тэдний үйл ажиллагааг дэмждэг. НАТО-гийн Аюулгүй байдлын судалгааны шинжээчдийн үзэж байгаагаар тэдний жилийн төсөв улам нэмэгдэж байгаа бөгөөд жилийн 1,6 тэрбум доллар хүрсэн гэжээ.

АНУ-ын цэргүүд Афганистанаас гарах болсон шалтгаан

Афганистаны үндсэн Засгийн газрын эрхийг тогтворжуулахын зэрэгцээ Аль Кайда, Исламын улс бүлэглэл зэрэг үндэстэн дамнасан террорист байгууллагуудын эсрэг АНУ нь хэдэн тэрбумаар хэмжигдэх асар их долларын зардал гаргасан.

АНУ-ын дэмжлэгтэйгээр байгуулагдсан Засгийн газар маш түргэн хугацаанд Талибан бүлэглэлд бууж өгсөн явдал нь бүс нутгийн ашиг сонирхол, Орос, Хятад, Энэтхэг болон Барууны улс орнуудын стратегийн хэтийн төлөвт гэнэтийн өөрчлөлт оруулсан. Тэд засгийн эрхийг авсан даруйдаа 1996 онд байсан Талибан бүлэглэл шиг хатуу дэглэм Афганистаны иргэдэд тогтоохгүй гэж дэлхий нийтэд мэдэгдсэн ч НАТО-гийн гишүүн улсууд үүнд нь итгэхгүй байгаагаа илэрхийлсэн. Түүгээр ч зогсохгүй талибанчуудын удирдлага дор Аль Кайда байгууллагын хэдэн зуун гишүүд байгаа нь олон улсыг түгшээж байна гэж үзэх болов.

Афганистаны ирээдүй хэрхэх вэ?

Трампын Засаг захиргаа 2020 оны 2 дугаар сард Афганистаны Засгийн газрын ямар ч оролцоогүйгээр талибанчуудтай гэрээ байгуулсан. Дараа Жое Байден энэ оны 9 дүгээр сараас цэргүүдээ бүр мөсөн Афганистанаас гаргана гэдгээ нээлттэй зарласан. Энэ нь талибанчуудад тэдний ноёрхлоо тогтоох хугацааг нарийн зааж өгсөн явдал болоод зогсохгүй хүчээ нөөж, засгийн эрхийг авах таатай боломж болсон юм.

Тэдний удирдагчид дайчдадаа ямар ч хашаа, байшин, хувийн эзэмшлийн газар эзнийх нь зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг хориглосон. Мөн удахгүй шинэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг танилцуулна гэжээ. Тус бүлэглэлийн хэвлэлийн төлөөлөгч Мухаммед Наим Бид бусад улс орнуудтай эрх тэгш, хамтын сайн харилцаатай байхыг эрмэлзэж байна гэжээ.

Гэвч Кабул дахь Олон улсын нисэх онгоцны буудалд газардсан сүүлийн хэдэн онгоцонд сууж, эх орноосоо дүрвэх гэсэн хэдэн мянган иргэдийн бөөгнөрөл үүсээд байна.

Эмэгтэйчүүдэд ямар дүрэм журам үйлчлэх вэ

Талибанчууд эргэж ирснээр Афганистаны иргэдийн өдөр тутмын амьдралд олон талаар нөлөө үзүүлж байна. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд

боловсрол эзэмших, хөдөлмөрлөх эрхтэй байсан эмэгтэйчүүд, охидод одоо шашны илүү хатуу шаардлага тавигдана. Шинэ Засгийн газар байгуулагдаж, эмэгтэйчүүдийг олон нийтийн газар явахдаа ямар дүрэм журам баримтлахыг зааж өгнө гэжээ. Ямар ч гэсэн биеийн аль нэг хэсэг, царайгаа гаргасан хувцас өмсөх, ажил эрхлэхийг хатуу хориглох бололтой. Зарим эмэгтэй сэтгүүлчид болон бусад хүмүүсийн ярьж буйгаар талибанчууд иргэдийн хаагийг бүртгэж, айл бүрээр явж, нэгдсэн тооллого хийж байгаа аж. Эх орноосоо дүрвэж чадсан хүмүүсийн хэлснээр тэд тосгоны иргэдээс гэрлээгүй эмэгтэйчүүдийг бүртгэн авч, дайчдынхаа эхнэр болгохыг шаардсан гэжээ. Тиймээс тус улсын охид, эмэгтэйчүүдийн хувь заяа тун хэцүү байдалд орсон гэж үзэж болно.

“Куб” камиказе дроныг онцлов

ОХУ-ын зэвсэг үйлдвэрлэгч “Клашников” концерн 8 дугаар сарын сүүлээр Москвад болсон “АрМИ-2021” цэрэг-техникийн форум, үзэсгэлэнгийн үеэр бөмбөг тээсэн жижиг хэмжээтэй дроныг танилцуулсан. Нэгж тус бүрд 3 кг жинтэй бөмбөг суурилуулж, дайсны хөлөг онгоц эсхүл бусад байг устгах боломжтой ажээ. Мөн дайсны радарт илрэхгүйгээр нислэг хийдэг давуу талтай юм. Энэ нь 2019 оны “КУВ” төслийн хамгийн сүүлийн өөрчлөлт хийгдсэн загвар гадгийг онцлов.

Одоогийн байдлаар тус компани туршилтуудаа бүрэн хийж дуусгасан бөгөөд 15 хүртэлх нэгж ийм төрлийн дроныг нэгэн зэрэг байршуулах боломжтой тусгай хөөргөчийг давхар бүтээжээ. Электрон хөдөлгүүр нь дуу чимээ гаргадаггүй байхаар зохион бүтээгдсэн байна. Далай тэнгис, хуурай газар, агаарын орон зайн алинд нь ч гэсэн нөхцөлт байг устгах боломжтой.

ОХУ-ын зэвсэг үйлдвэрлэгч “Клашников” концерний зэвсгийн шинжээчид хэлэхдээ “Энэ төрлийн техник дэлхийн зах зээл дээр үүнээс өөр байхгүй. Гадаадын компаниуд ихэнхдээ 80 кг бөмбөг тээх дрон зохион бүтээж байна. Мэдээж манай камиказе дронтой харьцуулахад тэдгээр нь илүү хүчин чадалтай боловч илүү үнэтэй, мөн дуу чимээ ихтэй. Үүнд гол ялгаа нь байгаа юм. Харин бид жижигхэн хэмжээтэй, радарт үл илрэх технологи бүхий дрон зохион бүтээхийг хүссэн” гэв. Эхний ээлжид ОХУ-ын БХЯ-ны захиалгын дагуу эдгээр камиказе дроныг Оросын зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдэд нийлүүлэх ажлыг хийх бөгөөд дараагийн ээлжид гадаадын зах зээл рүү экспортлох асуудал яригдах төлөвтэй байна. Үүнтэй төстэй дрон хамгийн сүүлд 2020 онд Нагорно-Карабахын мөргөлдөөнд Арменийн, Азербайжаны талууд байлдаж байхад ашиглагдсан. Тодруулбал, Азербайжаны тал Арменийн хуягт тээвэрлэгч, зенитийн пуужингийн цогцолборуудыг камиказе дрон ашиглан устгаж байсан юм. Сирийн дайны үеэр ч мөн Оросуудын эсрэг террорист бүлэглэлүүдийн ашиглаж байсан ийм төрлийн дронуд маш аюул тарьж байжээ. Тодруулбал Сири дэх Оросын Хмеймим агаарын бааз руу Сирийн террорист бүлэглэлүүд хэд хэдэн камиказе дронор халдлага хийж байсан. Ердөө толгоомын хэмжээтэй жижиг нисдэг тэрэг угсраад хэдэн арван тэсрэх бөмбөг тээлгээд цэргийн бааз руу нисгэж байв. Жижиг тэсрэх бөмбөг их биедээ тээсэн ердөө 15 ам.долларын үнэтэй дроныг дунд, богино тусгалын “Панцырь С-1” зенитийн пуужин- их бууны цогцолбороор устгахад тун хэцүү юм. Тус цогцолборын залуурт пуужин нь 5 дугаар үеийн сөнөөгч онгоц болон бусад цэргийн зэвсэг техникийг устгах зориулалттай ажээ.

Панцырь С-1 зенитийн пуужин- их бууны цогцолборын сум хэдэн мянган ам.долларын үнэтэй. Үүнд чиглүүлэгч пуужин, их бууны сум орно. Иймд Оросын цэргийн шинжээчид хямд үнэтэй зэвсгийг зохион бүтээж зүйтэй гэж үзсэн байна.

“Куб” камиказе дроны тухайд цагт 130 км хүртэл хурдтай нисдэг бөгөөд нислэгийн хугацаа 30 хүртэл минут байж болдог. Далавч нь нэг метр ч хүрэхгүй бөгөөд гурван кг хүртэл жинтэй байлдааны цэнэгт хошуу тээх хүчин чадалтай. 2019 оноос хойш Сири дэх Оросын цэргүүд террорист бүлэглэлүүдийн эсрэг уг дроныг ашиглаж, туршсан гэдгийг шинжээчид мөн энэ үеэр онцлов.